

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭД

2025 оны 03 дугаар сарын

25-ны өдөр

Улаанбаатар хот

Монгол Улсын Дээд Шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны

2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 001/ХТ2025/0013 дугаартай тогтоолыг

шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлт гаргах тухай

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1.4.-т “гуравдагч этгээдийг татан оролцуулалгүйгээр шүүхээс хэргийг хянан шийдвэрлэсэн нь шүүхийн шийдвэрт ноцтойгоор нөлөөлсөн” бол хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр /анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах болон хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн магадлал, тогтоол/-ийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан үзэж болно гэж заасны дагуу УДШ-ийн дээрх тогтоолыг хянуулахаар хүсэлт гаргаж байна. Үүнд:

1.Анхан шатны шүүх Улсын бүртгэлийн ерөнхий газрын хяналтын улсын ахлах байцаагчийн 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 6572 дугаартай дүгнэлтийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа гуравдагч этгээдүүдийг хэрэгт татан оролцуулаагүй байна. Давж заалдах шатны шүүх болон хяналтын шатны шүүх энэ үндэслэлээр хэргийг анхан шатны шүүх рүү буцаах ёстой байжээ.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5-д “Нэхэмжлэлийн шаардлагад тодорхойлсон захиргааны акт, захиргааны гэрээний улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдийг гуравдагч этгээд гэнэ” гэж, 22 дугаар зүйлийн 22.1-т “Үндсэн нэхэмжлэлийн шаардлагаар үссэн маргааны үйл баримтын талаар бие даасан шаардлага гаргасан, эсхүл эдгээрийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа гэж үзсэн гуравдагч этгээдийг тухайн этгээдийн хүсэлтээр, эсхүл шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулна” гэж тус тус заасан.

Нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл хэсэгтээ “МУИС-ийн төгсөгчид, багш ажилчид, оюутнуудын эрх зөрчигдөж байна, 1998 оноос хойш үйл ажиллагаа явуулсан, 2002 оноос “Монголын үндэсний” гэх нэршлийг ашиглаж ирсэн, энэ хугацаанд маш их хөрөнгө оруулалт хийж ирсэн талаар дурдсан байдаг.

Гэтэл дээд шүүхийн тогтоолын 12 дугаар хуудас 46 дахь хэсэгт “Монголын Үндэсний Их сургууль” нэрээр суралцаж төгссөн төгсөгчдийн эрх ашиг хөндөгдөхгүй, одоо сурч байгаа оюутнуудын тухайд сургуулийн нэр өөрчлөгдөх нь тэдний сурч боловсрох эрхэд нөлөөлөхгүй....” гэж нотлох баримтгүй, үндэслэлгүйгээр дүгнэжээ.

Үүнээс үзвэл МУИС-ийн төгсөгчид, суралцагчид, оюутнуудийг анхан шатны шүүхэд гуравдагч этгээдээр татаагүй, гуравдагч этгээдээр оролцох боломжыг шүүх хангаагүй атлаа тэдний талаар дээд шүүх дүгнэлт хийсэн нь шүүхийн тогтоолд ноцтой нөлөөлсөн гэж үзэхээр байна.

Дээд шүүхийн тогтоолын 21-т “...сургуулийг бүртгэсэн бүртгэл нь илт хууль бус захиргааны актад тооцогдоно” гэж дүгнэсэн өөрөөр хэлбэл тогтоолоороо улсын байцаагчийн дүгнэлтийг хэвээр үлдээсэн атлаа МУИС нэрээр суралцаж төгссөн болон одоо сурч байгаа

оюутнуудын тухайд эрх нь зөрчигдөхгүй гэж нотлох баримтгүйгээр дүгнэж байгаа нь ойлгомжгүй, үндэслэлгүй, өөрийн шийдвэрээ үгүйсгэж байгаа агуулгатай байна.

Учир нь Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “илт хууль бус захиргааны акт гарсан цагасаас эхлэн эрх зүйн үйлчлэлгүй байна” гэж заасан. Шүүх 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн улсын бүртгэлийг илт хууль бус акт гэж үзэж байгаа бол МУИС-ийн энэ цаг хугацаанаас хойшх бүх төгсөгчид, одоо суралцаж байгаа суралцагчид, оюутнуудын эрх, ашиг сонирхол хөндөгдөж байна. Өөрөөр хэлбэл 2013-2025 оныг хүртэлх төгсөгчдийн диплом хүчингүй гэж ойлгохоор байна.

МУИС-ийн санхүүгийн албанаас гаргасан шинээр илэрсэн баримтаас үзэхэд “2014-2024 оны хооронд МУИС-ийн дипломын боловсролоос докторын зэргийн боловсрол хүртэлх сургалтад 9685 суралцагч төгсөж, 108.472.000.000 төгрөгийн төлбөрийг сургуульд төлжээ”. Энэ олон хүмүүс бүгд МУИС-ийн нэрээр диплом авсан. Дээд шүүхийн энэхүү тогтоолын улмаас маш их хэмжээний хөрөнгөөр олон мянган төгсөгчид хохирч байгаа нь шинэ баримтаар нотлогдож байна.

Одоо МУИС-д үүсээд байгаа нөхцөл байдал бол төгсөгчид, оюутнууд сургуульд төлсөн төлбөрөө буцааж сургуулиас авах, МУИС-иас өнгөрсөн хугацаанд олгосон диплом хүчинтэй эсэх, өөр сургуулийн нэрээр төгсөх эсэх, одоо суралцаж байгаа суралцагчид, оюутнууд МУИС-ийн дипломтой төгсөх эсэх, эдгээр хүмүүсийн сэтгэл санааны хохирлын асуудал яригдаж байна.

Дээд шүүхийн тогтоол гарснаар нийгэмд, хэвлэл мэдээллийн хэрэгслээр МУИС-ийн нэрийг улс хурааж авлаа, хууль бус сургууль байжээ, Монгол Улсын Их Сургуулийг хохироож байжээ, МУИС нь төгсөгч, оюутнуудыг хуурч байжээ гэх зэрэг мэдээлэл цацагдсан. Үүний улмаас төгсөгчид, оюутнууд, тэдний эцэг, эх, гэр бүлийн хүмүүс сургуулийн удирдлагаас биечлэн болон утсаар удаа дараа хандаж юу болоод байгаа талаар асуусаар байна.

2.Шүүх Монгол Улсын Их Сургуулийг гуравдагч этгээдээр татсан атлаа Монголын Үндэсний Их Сургуулийн төгсөгчид, оюутнуудыг гуравдагч этгээдээр татаагүй нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан “хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол болон бусад байдал, хуулийн этгээдийг өмчийн хэлбэр, эрх хэмжээгээр нь ялгаварлахгүй эрх тэгш байх зарчимд үндэслэн явагдана” гэсэн “шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим”-ыг зөрчсөн байна. Үүний улмаас хуулийн 6 дугаар зүйлд заасан хэргийн оролцогчдын мэтгэлцэх зарчим алдагдсан байна.

Хэрэгт авагдсан баримт, шүүхийн тогтоолыг судлан үзэхэд Монгол Улсын Их Сургуулийн ямар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь бодитоор хөндөгдсөн нь тодорхой бус, энэ талаар бичгийн нотлох баримт байхгүй байна. Харин Монголын Үндэсний Их Сургуулийн төгсөгчид, оюутнуудын бодит эрх, ашиг сонирхол шууд хөндөгдөн зөрчигдсөн байна.

Иймд МУИС-ийн төгсөгчийн холбоо, оюутнуудын холбоог шүүхэд гуравдагч этгээдээр таталгүй, тэдний шүүхэд эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах, мэтгэлцэх, шүүхийн өмнө эрх тэгш байх боломжийг олгоогүй нь шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолд ноцтойгоор нелөөлсөн байх тул Монгол Улсын Дээд Шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 001/ХТ2025/0013 дугаартай тогтоолыг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянаж, шүүхийн тогтоолыг хүчингүй болгож, хэргийг анхан шатны шүүхэд буцааж өгнө үү.

Хавсралт:

1."Монголын үндэсний их сургууль төгсөгчдийн холбоо" ГҮТББ-ын хүсэлт, Улсын бүртгэлийн гэрчилгээ

2."Монголын үндэсний их сургуулийн оюутны холбоо"ГҮТББ-ын хүсэлт, Улсын бүртгэлийн гэрчилгээ

3.МУИС-ийн 2014-2024 оны төгсөгчдийн тоо, төлсөн төлбөрийн хэмжээ

Жич: Итгэмжлэлийг 2025.03.10-ны өдөр Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хүргүүлж, хэргийн материалтай танилцсан болно.

Нийт ..6.. хуудастай.

НЭХЭМЖЛЭГЧИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧ



O.BATSAIYHAN

“МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН ОЮУТНЫ ХОЛБОО” ГҮТББ

2025 оны 03 сарын 25-ны өдөр

№ 08

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМД

Монгол Улсын Дээд Шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны
2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 001/ХТ2025/0013 дугаартай тогтоолыг
шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлт гаргах тухай

Улсын бүртгэлийн ерөнхий газрын хяналтын улсын ахлах байцаагчийн 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 6572 дугаартай дүгнэлт, Монгол Улсын Дээд Шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 001/ХТ2025/0013 дугаартай тогтоолын улмаас Монголын Үндэсний Их сургуульд суралцаж буй гадаад улсын 1365, дотоодын 7225, нийт 8590 оюутны эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдэж байна.

Бид Монголын Үндэсний Их сургуулийг сонгон, зохих төлбөрөө төлж суралцаж байна. Өөрөөр хэлбэл сургууль болон оюутан, тэдний эцэг, эх нар хүсэл сонирхол, итгэл үнэмшлээрээ гэрээ, хэлцэл байгуулсан. Оюутан бид МУИС-ийг төгсөж, цаашид ажиллаж амьдарна.

Одоо сургууль дээр болж байгаа асуудал бол бид МУИС гэсэн нэрээр төгсөх юм уу, өөр сургуулийн нэрээр төгсөх юм уу, сургуульд төлсөн төлбөрөө сургуулиас нэхэмжлэх үү, улсын бүртгэлийн ерөнхий газрын улсын байцаагчаас нэхэмжлэх үү, өөр сургуульд шилжин суралцах уу гэсэн асуудал хөндөгдөөд байна. Нийгмийн сүлжээ фээсбүүк, Х сүлжээ, мэдээллийн сайтуудаар МУИС хууль бус байжээ, оюутнууд нь Монгол Улсын Их сургууль гэж андуурч элсжээ, шүүх дээр ялагджээ гэх зэргээр мэдээлэл цацагдаж бид бүхнийг маш хэцүү байдалд оруулж байна. Цаашлаад нийгэмд гадуурхагдах, эцэг эх, ар гэрийн хүмүүс санхүүгийн хүндрэлтэй нөхцөл ороод байна.

МУИС-ийн Оюутны холбоо, түүний төлөөллийг шүүхэд яагаад оролцуулахгүй, мэтгэлцэх, эрх, ашгаа хамгаалах боломж олгоогүйд гайхаж байна. Биднийг шүүхэд гуравдагч этгээдээр оролцуулаагүй атлаа Монгол Улсын Их сургуулийг шүүхэд оролцуулж эрх нь зөрчигдсэн гэж дүгнэсэн байна. Харин суралцагч бидний эрх зөрчигдөхгүй гэж дүгнэсэн нь ойлгомжгүй бөгөөд хууль бус гэж үзэж байна.

Иймд дээд шүүх тогтоолыг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан үзэж тогтоолыг хүчингүй болгож, хэргийг анхан шатны шүүх рүү буцааж, Оюутны холбоо, түүний төлөөллийг шүүхэд гуравдагч этгээдээр оролцуулж, эрх, хууль ёсны ашиг сонирхолоо хамгаалах, шүүхэд мэтгэлцэх, шүүхийн төмнөөрх тэгш байх боломжоор хангаж өгнө үү.





МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
000332523

2025.02.26

/Бүртгэсэн он, сар, өдөр /

9072015983

/Хувийн хэргийн дугаар /

7126449

/Регистрийн дугаар /

Монголын үндэсний их сургуулийн оюутны
холбоо

Холбоо /ГҮТББ/

/Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/Үүсгэн байгуулах баримт бичиг /

Тогтоол

/шийдвэрийн нэр /

01

/дугаар /

2025.02.24

/он, сар, өдөр /

94990

Сургуулийн захиргаа, МОХ, төрийн болон төрийн бус байгууллагуудтай
хамтран ажиллах, оюутнуудын эрх ашгийг төлөөлөн хамгаалах, тэдэнд
хандсан ажиллагааг идэвхитэй явуулах, оюутнуудын суралцах ага
барил, хамт олноо манлайлах чадавхийг болон бие даан хөгжих бүхий
л бололцог бүрдүүлнэ

/Код/

/Үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

/хугацаа /

2

/гишигдийн тоо /

0.00

/хөрөнгийн хэмжээ, мянган төгрөөнөөр /

Улаанбаатар, Сүхбаатар, 7-р хороо, 11 хороолол, эрхүүгийн, 7, 182 тоот Утас: 91919129

Утас2: , Факс:


/хуулийн этгээдийн албан ёсны хаяг /



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
СОНГИНОХАЙРХАН ДУРГААГЫН УЛСЫН БҮРТГЭЛИЙН

/Бүртгэсэн байгууллагын нэр /

УЛСЫН БҮРТГЭЧ СҮРГҮҮЛЧ ЯНЖИНДУЛАМ
/тэмдэг/ 171 /гарынчусэг/



МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтантэмдэг
1	<p>Лхагвасүрэн овогтой Мөнхбат-г Удирдах зөвлөлийн дарга-г сонгосон(томилсон)-ыг бүртгээ. Баттогтох овогтой Нямдааваа-г Гүйцэтгэх захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгээ.</p>  <p>МОНГОЛ УЛС</p> <p>2025.02.26</p> <p>378</p> <p>2025.03.25 ... он ... сар ... өдөр Бүртгэлийн № Нийслэлийн тойргийн нотариатч Х.Хосжаргал би энэ хуулбарын үнэн зөвийг гэрчилэв. Нотариатч </p>	2025.02.26 2025.02.26	Ч.Янжийнбүлэг Ч.Янжийнбүлэг 171

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дахь хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчин:



000332523

“МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛЬ ТӨГСӨГЧДИЙН ХОЛБОО” ГҮТББ

2025 оны 03 сарын 25-ны өдөр

№ 09

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМД

Монгол Улсын Дээд Шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны
2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 001/ХТ2025/0013 дугаартай тогтоолыг
шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлт гаргах тухай

Улсын бүртгэлийн ерөнхий газрын хяналтын улсын ахлах байцаагчийн 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 6572 дугаартай дүгнэлт, Монгол Улсын Дээд Шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 001/ХТ2025/0013 дугаартай тогтоолын улмаас Монголын Үндэсний Их сургуулийг төгссөн бид бүхний эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байна.

Бид Монголын Үндэсний Их сургуулийг амжилттай төгсөж, энэ сургуулийн дипломыг авч ажил хөдөлмөрийн гараагаа эхэлсэн. Ямар ч хүн төгссөн сургуулиараа бахархаж, үүнийгээ үнэт зүйл, капитал, амьдрал ахуйг залгуулж байгаа чухал хүчин зүйл гэж боддог.

Гэтэл Улсын бүртгэлийн газрын мэргэжлийн бус байцаагч дүгнэлт гаргаж, үүнийг нь дээд шүүх зөвтгөн шийдсэн нь биднийг маш их цочирдуулж, хохироож байна. Ийм зүйл болсон нь бидний олон жил суралцсан хөдөлмөрийг үнэгүйтүүлж, нийгэмд хууль бус дипломтой, их сургууль төгсөөгүй гэх зэргээр гадуурхагдах нөхцлийг бүрдүүллээ. Энэ талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр шуугисаар байна.

Учир нь улсын байцаагч МУИС-ийн бүртгэлийг илт хууль бус захиргааны акт гэж үзсэн, дээд шүүх энэ дүгнэлтийг хэвээр үлдээсэн. Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “илт хууль бус захиргааны акт гарсан цагаасаа эхлэн эрх зүйн үйлчлэлгүй байна” гэж заасан. Шүүх 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн улсын бүртгэлийг илт хууль бус акт гэж үзэж байгаа бол энэ цаг хугацаанаас хойш бүх төгсөгчдийн эрх, ашиг сонирхол хөндөгдөж байна. Өөрөөр хэлбэл 2013-2025 оныг хүртэлх төгсөгчдийн диплом хүчингүй гэж ойлгохоор байна.

МУИС-ийг “2014-2024 оны хооронд МУИС-ийн дипломын боловсролоос докторын зэргийн боловсрол хүртэлх сургалтад 9685 суралцагч төгсөж, 108.472.000.000 төгрөгийн төлбөрийг сургуульд төлжээ”. Энэ олон хүмүүс бүгд МУИС-ийн нэрээр диплом авсан.

МУИС-ийн Төгсөгчдийн холбоо, төгсөгчдийн төлөөллийг шүүхэд яагаад оролцуулахгүй, мэтгэлцэх, эрх, ашгаа хамгаалах боломж олгоогүйд гайхаж байна. Биднийг шүүхэд гуравдагч этгээдээр оролцуулаагүй атлаа Монгол Улсын Их сургуулийг шүүхэд оролцуулж эрх нь зөрчигдсөн гэж дүгнэсэн байна. Харин төгсөгч бидний эрх зөрчигдэхгүй гэж дүгнэсэн нь ойлгомжгүй бөгөөд хууль бус гэж үзэж байна.

Иймд дээд шүүх тогтоолыг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан үзэж тогтоолыг хүчингүй болгож, хэргийг анхан шатны шүүх рүү буцааж, төгсөгчдийн холбоо, төгсөгчдийн төлөөллийг шүүхэд гуравдагч этгээдээр оролцуулж, эрх, хууль ёсны ашиг сонирхолоо хамгаалах, шүүхэд мэтгэлцэх, шүүхийн өмнө эрх тэгш байх боломжоор хангаж өгнө үү.



В.ДЭЛГЭРМАА

МУС-ИЙН 2014-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ТӨГСГӨЧДИЙН ГЕЛБЕР ТӨЛӨЛИЙН МЭДЭЭЛЭЛ

	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	Нийт төсөгтдийн төхөөрөмж	Суралсан жил	Үрэсвэрдэх жил	Сургалтын төхөөрөмж	Мөнгөн дүн
Диплом	0	0	0	0	0	0	16	21	21	10	68	3	204	1,200,000	244,800,000	
Бакалавр	597	719	786	1354	1022	467	729	815	1031	412	439	8371	4	33484	3,200,450	
Магистр	47	120	85	39	146	78	110	152	137	318	13	1245	2	2490	2,500,000	
Доктор	0	0	0	0	0	0	0	0	0	1	1	3	3	3,500,000	10,500,000	
<i>Нийт тоо</i>	<i>644</i>	<i>839</i>	<i>871</i>	<i>1393</i>	<i>1168</i>	<i>545</i>	<i>839</i>	<i>983</i>	<i>1189</i>	<i>751</i>	<i>463</i>	<i>9685</i>			<i>113,644,167,800</i>	

Нягтан бодогч С.Майдандэлэн
№ 5133816 Код 200-106

Scanned with
 CamScanner™



МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000332525

2025.02.26

/Бүртгэсэн он, сар, өдөр /

9072015985

/Хувийн хэргийн дугаар /

7126601

/Регистрийн дугаар /

Монголын үндэсний их сургууль
төгсөгчдийн холбоо

Холбоо /ГҮТББ/

/Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/Үүсгэн байгуулах баримт бичиг /

Тогтоол

/шийдвэрийн нэр /

01

/дугаар /

2025.02.24

/он, сар, өдөр /

94990

Төгсөгчид хоорондын харилцаа холбоог бий болгох, тэдний эрх ашгийг
хамгаалах, холбогдох мэдээ мэдээллээр хангах үүднээс төрөл бүрийн
уулзалт, хурал чуулган, олон нийтийн болон соёл урлаг, спортын арга
хэмжээнүүд зохион байгуулах, төгсөгчдийн мэргэжил дээшлүүлэх,
дипломын дараах сургалтад хамруулна

/Код/

/Үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

/хугацаа /

2

/гишигдийн тоо /

0.00

/хөрөнгийн хэмжээ, Мянган төгрөг/

Улаанбаатар, Сүхбаатар, 7-р хороо, 11 хороопол, эрхүүгийн, 7, 132 тоот, Утас1: 91919129,
Утас2: , Факс:

/хуулийн этгээдийн албан ёсны хаяг/



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
СОНГИНОХАЙРХАН ДУУРГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН

ХЭЛТЭС

БҮРТГЭГЧ

УЛСЫН БҮРТГЭГЧ
/тэмдэг/

Гарын/Усат/



Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/Д	Нэмэлт, өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэ
1	<p>Лхагвасүрэн овогтой Мөнхбат-г Удирдах зөвлөлийн дарга-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв. Ванчинсүрэн овогтой Дэлгэрмаа-г Гүйцэтгэх захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.</p>  <p>2025.02.26</p> <p>.... он ... сар ... өдөр Бүртгэлийн № Нийслэлийн тойргийн нотариатч Х.Хосжаргал би энэ хуулбарын үнэн зөвийг гэрчилэв. Нотариатч</p> 	2025.02.26 2025.02.26	Ч.Янжинбүлэг Ч.Янжинбүлэг

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн
хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хучи



000332525